

АГУУЛГА

I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
I.1 Төслийн талаарх мэдээлэл	2
I.2 Төслийн талбайн байршил	2
I.3 Орд ашиглах тусгай зөвшөөрөл	3
I.4 Уурхайн ажиллах горим, хүчин чадал	3
I.5 Далд уурхайн үндсэн үзүүлэлтүүд	4
I.6 Уурхайн календарьчилсан төлөвлөлт	4
I.7 Дэд бүтэц	6
I.7.1 Цахилгаан хангамж	6
I.7.2 Усан хангамж	6
I.7.3 Барилга байгууламж	7
II. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ГОЛ ЗОРИЛТ	8
II.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	8
II.2 Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөө	10
II.3 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	11
II.4 Тэр бум мод үндэсний хөтөлбөр	12
II.5 Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	12
II.6 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	12
II.7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	13
II.8 Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	15
II.9 Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	19
II.10 БОМТ-ний хэрэгжилтийг оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	20

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛ

Хүснэгт № I-1. MV-012342 тоот тусгай зөвшөөрлийн газарзүйн солбицол	2
Хүснэгт № I-2. Уурхайн үндсэн үзүүлэлтүүд	4
Хүснэгт № I-3. Далд уурхайн уулын ажлын горим	4
Хүснэгт № I-4. Календарьчилсан төлөвлөлт /малгалтын уртаар/	5
Хүснэгт № I-5. Хотхоны усны хэрэглээ	6
Хүснэгт № I-6. Зам талбайн усалгаа	7
Хүснэгт № I-7. Ногоон байгууламжийн усалгаа	7
Хүснэгт № I-8. Төслийн хугацаанд уурхайн нийт зарцуулах усны хэрэгцээний тооцоо	7
Хүснэгт № II-1.	8
Хүснэгт № II-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүний зардал	9
Хүснэгт № II-3. Нийт нөхөн сэргээлтийн зардал, аргачлал	10
Хүснэгт № II-4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	11
Хүснэгт № II-5. 0.3га талбайн	12
Хүснэгт № II-6. Хог хаягдлыг менежментийн төлөвлөгөө	13
Хүснэгт № II-7.	16
Хүснэгт № II-8.	19
Хүснэгт № II-9. БОМТ-г оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	20

ЗҮРГИЙН ЖАГСААЛ

Зураг№ I-1. Төслийн талбайн байршил	2
Зураг№ I-2. Ил уурхай хүрээ хязгаар болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай	3
Зураг№ I-3. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд үүсгэсэн ил уурхай	4

I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

I.1 Төслийн талаарх мэдээлэл

Төслийн нэр: Өргөний хайлуур жоншны орд

Төсөл хэрэгжүүлэгч: “Жунзень” ХХК, услын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9019088027, регистрийн дугаар: 5088755


Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо зайсан, Файдс цамхаг, 401 тоот. Утас: 99214871

Тусгай зөвшөөрөл: MV-012342

Талбайн хэмжээ: 45 га

I.2 Төслийн талбайн байршил

Өргөний хайлуур жоншны орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 510 км, Дорноговь аймгийн төв Сайншанд хотоос зүүн урагш 60 км, Өргөн сумын төвөөс баруун урагш 5 км-т оршино.



Зураг№ I-1. Төслийн талбайн байршил

Хүснэгт № I-1. MV-012342 тоот тусгай зөвшөөрлийн газарзүйн солбицол


Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг		
	Град	Мин	Сек	Град	Мин	Сек
1	110	45	16.94	44	42	24,81
2	110	45	16.94	44	42	1,68
3	110	44	49,69	44	42	1,68
4	110	44	49,59	44	42	20,95
5	110	44	40,44	44	42	20,88
6	110	44	42,9	44	42	24,81

I.3 Орд ашиглах тусгай зөвшөөрөл


Ашигт малтмалын газраас “Жунзень” ХХК-нд Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт орших “Өргөн” хайлуур жоншны орд нэртэй газар 44.98 гектар талбай бүхий эдэлбэрт ашигт малтмал ашиглах эрхийг олгож MV-012342 дугаар бүхий гэрчилгээтэй 2007 оны 01 сарын 24 өдөр олгосон байна.

I.4 Уурхайн ажиллах горим, хүчин чадал

Тус ордын I-VI хүдрийн биетийн хувьд газрын гадаргаас 40 м гүнд, 250 м үргэлжлэх ба дундаж зузаан нь 3.6-4.32 м байна. Иймд тус ордын уул-геологийн хүчин зүйлээс харахад ил уурхайн аргаар ашиглах боломжтой хэдий ч ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд ил уурхай үүсгэх үеийн нөхцөлийг авч үзэв. Дараах зураг III.1-д хүдрийн биетүүдийг бүрэн олборлох үеийн ил уурхайг үүсгэх үед ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хилээс илүү гарч байгаа нь харагдана. Дараагийн зураг нь өөрийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд ил уурхайн хил хязгаарыг оруулсан байдлаар үүсгэсэн.



Зураг № I-2. Ил уурхай хүрээ хязгаар болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай



Зураг № I-3. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд үүсгэсэн ил уурхай

I.5 Далд уурхайн үндсэн үзүүлэлтүүд

Хүснэгт № I-2. Уурхайн үндсэн үзүүлэлтүүд

№	Үндсэн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Нийт	Жилийн дундаж
1	Ордын геологи			
1.1	Геологийн нөөц	мян.тн	579.75	
1.2	Ашиглалтын нөөц	мян.тн	555.15	
1.3	Үйлдвэрлэлийн нөөц, /нийт/	мян.тн	544.03	
1.4	Бүтээгдэхүүн гаргалтын хэмжээ ФК-75	мян.тн	54.4	8.2
1.5	Уулын цулын хэмжээ	мян.м³	324.49	64.9
1.6	Төсөл хэрэгжих хугацаа	жил	7	
1.7	Уурхайн жилийн хүчин чадал	мян.тн/жил	80.0	
1.8	Уурхайн ашиглалтын систем	Дэд давхраар нураах		
1.9	Баяжуулах арга	Гар аргаар ангилан ялгах		

I.6 Уурхайн календарьчилсан төлөвлөлт

Өргөний хүдрийн 10-р бүс I-VI-н хүдрийн биетүүдийг ашиглах хугацаа 7 жил болж байна.

Хоногт үргэлжлэх ээлжийн хугацаа газрын дор буюу далд уурхайд 7 цаг, газрын дээр буюу гар аргаар ялгах хэсэг, цахилгаан хангамж зэрэг болон бусад хэсгүүдэд 8 цаг байна.

Хүснэгт № I-3. Далд уурхайн уулын ажлын горим


Жилийн сарууд	Календарь хоног	Амралт, сул зогсолт, хон				Ажиллах хоног	Хоногийн ээлжийн тоо
		Баяр ёслол	Цаг агаар	Төлөвлөгөөт засвар үйлчилгээ, зогсолт	Төлөвлөгөөт бус сул зогсолт		
1	31	-	-	2	-	29	3
2	28	-	-	2	-	26	3
3	31	3	6	8	1	14	3
4	30	-	2	2	1	26	3
5	30	-	-	2	1	28	3
6	31	1	-	2	1	28	3

7	31	4	-	2	1	25	3
8	31	-	1	2	1	28	3
9	30	-	-	2	1	28	3
10	31	1	7	8	1	15	3
11	30	-	-	2	-	28	3
12	31	-	-	2	-	29	3
Жилд	365	9	16	36	8	304	36

Өргөний 10-р хүдрийн бүсийн I-VI-р хүдрийн биетүүдийг ашиглах 7 жилийн хугацаанд ашиглах бөгөөд жил бүрийн уулын ажлыг малталтын урт болон уулын ажлын эзлэхүүнээр дараах хүснэгтүүдэд үзүүлэв.

Хүснэгт № I-4. Календарьчилсан төлөвлөлт /малталтын уртаар/

Д/д	Малталтын төрөл	1-р жил	2-р жил	3-р жил	4-р жил	5-р жил	6-р жил	7-р жил	Нийт дүн
		м	м	м	м	м	м	м	м
1	Тээврийн съезд	495.9	208.1	193.4	190	195	195	82.2	1559.6
2	Квершлаг	269	132.3	112.4	120.8	132.3	151.7	85.5	1004
3	Тээврийн штрэк	737.2	875	621.7	724.3	827.9	599.1	294.2	4679.4
4	Маневрын ниш	90	90	63	81	90	36	27	477
5	Блокийн восстающий	708	410	270	312	338	324	156	2518
Нийт		2300.1	1715.4	1260.5	1428.1	1583.2	1305.8	644.9	10238



Зураг № I-1. Календарьчилсан төлөвлөгөөний график /малталтын уртаар/

I.7 Дэд бүтэц

I.7.1 Цахилгаан хангамж:

Уурхайн цахилгааныг дизель генератороор хангах бөгөөд энэ ашиглалтын үед цахилгаан ашиглах том хэрэглэгч байхгүй тул төсөл захиалагчийн техникийн даалгаврын дагуу уурхайн цахилгаан хангамжид дизель генератор ашиглахаар төлөвлөв.

I.7.2 Усан хангамж:

Хотхоны усны хэрэглээ:

Уурхайн хотхонд үйлдвэрийн ажилчид болон удирдах албан тушаалтнууд нийтдээ жилд 137 хүн ажиллахаар тусгасан. Уурхай жилд 304 хоног ажиллана. Уурхайн унд ахуйн усыг Дорноговь аймгийн Өргөн сумын Сүмийн булаг нэртэй газарт төслийн талбайгаас 500 метрийн зайд байрлах “Лотус-Амгалан” ХХК-ийн эзэмшлийн 2.2 л/с ундаргатай гүний худгаас ус нийлүүлэх гэрээний дагуу хангана. Төслийн шатанд уурхайн технологийн хэрэгцээнд ус ашиглахгүй. Ус ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй /тайланд хавсаргав/.

Төслийн усны хэрэгцээг БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм” -оор тооцоход

Хүснэгт № I-5. Хотхоны усны хэрэглээ

Норм, л/хоног	Хүний тоо, ш	Цэвэр усны хэрэглээ		
		м³/хоног	Жилд ажиллах хоног	мян.м³/жил
150	137	20.55	304	6,247.20

Зам усалгаа, техникийн усны хэрэглээ:

Уурхайн замын тоосжилтыг дарахад 1м² талбайг 2л усаар услахаар төлөвлөсөн. Технологийн замын талбай нь нийтдээ 30000 м² талбай болно. Уурхайн нь жилд 304 хоног ажиллах ба хур бороотой өдрийг тооцож жилд 100 удаа услахаар байна.

Уурхайд орж ирэх нийт усны хэмжээ хүдрийн биетийн хэмжээнд тээврийн сьездэд **орж ирэх усны хэмжээгээр 43.2 м³/хон, 0.5 л/с байна.**

Хоногт 43.2

Сард 1296.0

Жилд 15552.0 м³ буюу 15.552 мян.м³/жил ус уурхайд орж ирэхээр байна.

Уурхайн тоосжилт болон ногоон байгууламжийн усыг уурхайд орж ирэх шүүрлийн усаар хангахаар төлөвлөсөн.

Хүснэгт № I-6. Зам талбайн усалгаа

№	Хэрэглэгчийн нэр	Цэвэр усны хэрэглээ				мян.м³/жил
		Норм л/хоног	Хоногийн хүчин чадал	м³/хоног	Жилд ажиллах хоног/тоо	
1	Зам талбайн усалгаа	2.0	30000	60.0	100	6,000.0

Ногоон байгууламжийн усалгаа:

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайд жил бүр 300 ширхэг навчит мод тариална.

Хүснэгт № I-7. Ногоон байгууламжийн усалгаа

Ширхэг /бут сөөг/	л	нийт	жилд услах тоо	м³/хон	Мян.м³/жил
300	35.00	10500.00	70	2.45	735.00

Уурхайд жилд 15.552 мян.м³/жил ус орж ирэх бөгөөд үүнээс уурхайн тоосжилт ногоон байгууламжийн усалгаанд 6.73 мян.м³/жил ус ашиглахаар байна.

Хүснэгт № I-8. Төслийн хугацаанд уурхайн нийт зарцуулах усны хэрэгцээний тооцоо

№	Төслийн жил	Зам талбайн усалгаа мян.м³/жил	Ногоон байгууламж мян.м³/жил	Хотхоны хэрэглээ, мян.м³/жил	Уурхайн нийт хэрэглээнд, мян.м³/жил
1	1-р жил	6,000.0	735.00	6,247,20	12,982.2
2	2-р жил	6,000.0	735.00	6,247,20	12,982.2
3	3-р жил	6,000.0	735.00	6,247,20	12,982.2
4	4-р жил	6,000.0	735.00	6,247,20	12,982.2
5	5-р жил	6,000.0	735.00	6,247,20	12,982.2
6	6-р жил	6,000.0	735.00	6,247,20	12,982.2
7	7-р жил	6,000.0	735.00	6,247,20	12,982.2
	Нийт	42,000.0	5,145.0	43,730.4	90,875.4

I.7.3 Барилга байгууламж

Ажилчдын хотхон нийт 137 хүн ажиллахаас нэг ээлжид 50 хүн зэрэг байрлах хүчин чадалтай. Ажилчид таваараа амьдрах ажилчдын байр, конторын байр, хувцас угаалгын газар, бие засах болон ажилчдын халуун усны газар, дизелийн байр, агуулах, харуулын байр зэрэг барилга байгууламжууд байна. Агуулах, түлшний агуулах зэрэг байгууламжууд байна.

II.

II. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ)-г Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын хавсралтын дагуу боловсруулав.

Хүснэгт № II-1. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардал

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө		1-р жил	2-р жил	3-р жил	4-р жил	5- жил	6-р жил	7-р жил	Нийт зардал (сая.төг)
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4.5	4.5	4.5	4.5	4.5	4.5	4.5	31.5
2		Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2.0	2.0	2.0	2.0	2.0	2.0	2.0	14.0
3		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1.5	1.5	1.5	1.5	1.5	1.5	1.5	10.5
4		Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	2.28	2.28	2.28	2.28	2.28	2.28	2.28	16.0
5		Нөхөн сэргээлт, ногоон байгууламж	-	-	-	-	-	-	-	-
6		Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	0.38	0.38	0.38	0.38	0.38	0.38	0.38	2.66
Нийт зардал			10.66	10.66	10.66	10.66	10.66	10.66	10.66	74.62

II.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгав.

Хүснэгт № II-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүний зардал

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /сая.төг /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Агаар мандалд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх Арга хэмжээ				
Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Зам, талбайн усалгааны хэмжээ, норм, горимыг сар, улирлаар оновчтой тогтоох;	Ажиллах нийт хугацаанд Талбайн хэмжээнд	Үйл ажиллагааны зардлаар	Ажиллах хугацаанд
	Тэсэлгээний үеийн тоосжилт бууруулах, салхины чиглэл хурдтай уялдуулж зохицуулах, усан дэр ашиглах	- Ажиллах нийт хугацаанд - Талбайн хэмжээнд	Үйл ажиллагааны зардлаар	Ажиллах хугацаанд
	Технологийн зам талбайг засаж сайжруулах замын тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Олборлолтын талбайн хэмжээнд	2.0	
	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах;	Ажиллах нийт хугацаанд Бүх хүнд механизм	Үйл ажиллагааны зардлаар	Ажиллах хугацаанд
	Тоосжилтоос урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа явуулах;	Ажиллах нийт хугацаанд Нийт ажилчдад	0.5	Ажиллах хугацаанд
Дүн			2.5	
Усан орчинд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга Хэмжээ				
Ахуйн хаягдал, шатах, тослох материал ба бусад хаягдлаас бага гүний уст давхарга болон хөрс ургамал бохирдох	Тоосжилт дарах үйл ажиллагаанд ашиглах гэж байгаа усыг MNS-4943-2015стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг тогтмол хянах, шинжилгээнд хамруулах	төлөвлөгөөт онд	Үйл ажиллагааны зардлаар	1-2 р улиралд
	Ажилчид болон уурхайн нөлөөллийн бүсэд байх ард иргэдийн унд ахуйн хэрэгцээний усны чанарт хяналт тавьж ажиллах	Ажиллах нийт хугацаанд - Боломжтой 2 газарт	1.0	2-3 р улиралд
Дүн			1.0	
Хөрсөн бүрхэвч, гадаргын хэлбэр төрхөд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах Арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ				

Ахуйн хаягдал, шатах, тослох материал ба бусад хаягдлаас хөрс бохирдох	Бохирдсон хөрсийг цэвэрлэх, ариутгах арга хэмжээ авч байх	- Ажиллах нийт хугацаанд - Тухай бүрт	0.5	Ажиллах хугацаанд
	Усгүйжүүлэх технологи алдагдснаас бохирдолт, бохирдсон урсац үүсэх улмаар бохирдолт бий болохоос хамгаалах арга хэмжээ авах	- Ажиллах нийт хугацаанд - Тухай бүрт	-	Ажиллах хугацаанд
Автомашин тээвэрлэлтийн үед осол аваарь гарах	Автомашин хурдыг боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах	- Ажиллах нийт хугацаанд - Тухай бүрт	0.5	Ажиллах хугацаанд
Дүн			1.0	

II.2 Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн ажлуудыг холбогдох стандартын дагуу гүйцэтгэх болно. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS-5917-2008, Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ерөнхий шаардлага MNS-5918-2008

Хүснэгт № II-3. Нийт нөхөн сэргээлтийн зардал, аргачлал

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт өртөг (сая.төг)	Баримтлах стандарт, аргачлал
Техникийн нөхөн сэргээлт	Дүүргэлт	14 га талбайд дүүргэлт гүйцэтгэх	-	MNS-5917-2008,
Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрс хамгаалах	Шимт хөрсний овоолго үүсгэх	-	
Нийт			Үйл ажиллагааны зардлаар	

II.3 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг энд тусгана.

Хүснэгт № II-4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

ах	Нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Газар хөдлөлт	Зохих зураг төслийн стандартыг ашиглан гүйцэтгэгч байгууллагад шаардлага тавих, байгууламжийг улсын комисст хүлээлгэн өгөх	Төслийн талбай	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	Төсөл эхлэхийн өмнө нэг удаа
Аянга цахилгаан	Аянга зайлуулагчийг ЦС-ын байгууламжийн ойролцоох өндөрлөг газруудад суурилуулах. ЦС-ын цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх	Төслийн талбай		Төсөл эхлэхийн өмнө нэг удаа
Аадар бороо	Барилга байгууламжуудын зураг төсөл, чанарт цаг агаарын нөхцөлүүдийг тусгах, уурхайг үерээс хамгаалсан далан байгууламжтай болгох	Төслийн талбай		Төсөл эхлэхийн өмнө, нэг удаа
Шороон шуурга	Уурхайд онцгой байдлын журам боловсруулан мөрдөж ажиллах	Төслийн талбай		Төслийн хугацаанд байнга
Үер	Гадаргын усны урсацыг өөрчлөх, үерийн далан шуудуу татах, хүмүүст үерийн анхааруулга өгч хүний амь нас, дэд бүтцийг хамгаалах	Төслийн талбай		Төслийн хугацаанд, аль болох хур борооны улирлаас өмнө
Халдварт өвчин	Өндөр эрсдэлтэй амьтадтай (шувууд) харьцахгүй байх хангалттай хэмжээний хамгаалалтын хэрэгсэлтэй байх (амны хаалт гэх мэт)	Төслийн талбай		Төслийн хугацаанд, жил бүр
Нефть болон химийн аюултай бодис асгарах	Ашиглалт, тээвэрлэлт, хадгалалт зэрэгт анхаарал хандуулж холбогдох журам боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай.	Төсөл хэрэгжих бүс нутаг		Төслийн хугацаанд байнга
1 жилд		2.0 сая төгрөг		
7 жилд		14.0 сая төгрөг		

II.4 Тэр бум мод үндэсний хөтөлбөр

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, сангийн сайдын хамтарсан 2021 оны 07 сарын 09-ны өдрийн А/172, 116 дугаарт “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын нормативыг шинээр болон шинэчлэн батлах тухай” хөтөлбөрийг тусгав.

Хүснэгт № II-5. 0.3га талбайн ойжуулалтын зардал

№	Дүйцүүлэн хамгаалах зардал	Хамгаалах арга хэмжээ	Хамгаалах арга хэмжээний цар хүрээ, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	“Тэрбум мод” үндэсний хөтөлбөр	Сум орон нутгийн хэмжээнд ойжуулах талбайд элсний нүүдлийг сааруулах, зогсоох зорилгоор навчит модоор тариалалт хийх	Өргөн сумаас тогтоож өгсөн газарт	0.3 га /Агч - 150 Голт бор-150 Нийт-300 мод/	5 125 000 Үйл ажиллагааны зардлаар		Жил бүр	“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол

II.5 Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Тухайн төслийн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

II.6 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд хийсэн археологийн судалгаа, түүх соёлын өвийн судалгааны дүн, түүх, соёлын өв дурсгалуудын талаарх нутгийн иргэд, холбогдох байгууллагын мэдээлэлд үндэслэн түүх, соёлын өв дурсгалуудыг хамгаалах төлөвлөгөө боловсруулна.

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

II.7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт № II-6. Хог хаягдлыг менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Төсөл хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт, стандарт
							2025 он	
Хог хаягдлын цэгийг MNS 5906:2015 стандартад нийцүүлэн ашиглалтанд оруулах	Хатуу хог хаягдлын түр цэгийн хөрсийг цементлэж, битүүмжлэл сайтай 3 тасалгаатай хатуу хаягдлын цэгийн стандартын шаардлагад нийцүүлэн хөрснөөс тусгаарласан битүүмжлэл сайтай галд тэсвэртэй материалаар доторлох	Хог хаягдлын цэгт				500.0	+	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344:2011
Аюултай хог хаягдал	Химийн бодис бүтээгдэхүүнийг ашиглах, хадгалах, тээвэрлэх процессийг технологийн горимыг мөрдөж ажиллах, бодис бүтээгдэхүүний сав баглаа боодлын битүүмжлэлийг сайтар шалгаж байх, хаягдлыг ангилан ялгаж тусад нь зориулалтын сав агуулахад хадгалах	Аюултай хог хаягдлын хүрээнд				Үйл ажиллагааны зардлаар	+	БОСайд, ЭМСайдын 2003 оны 126/171 дугаар хамтарсан тушаалын I хавсралтаар батлагдсан Химийн бодисын хаягдлыг байгаль орчинд халгүй цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах технологийн

								аргачилсан заавар
Ахуйн хатуу хог хаягдлаар газрын гадарга бохирдох;	Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хаягдалын цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн битүүмжлэл сайтай хийх, хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах.	Төслийн талбайн бүх барилга байгууламж уудад				500.0	+	Хог хаягдлын тухай хууль
Хог хаягдал, ШТМ-ын хаягдал хурын усаар дамжин гүний усыг бохирдуулах	Унд ахуйн усыг лабораторын шинжилгээнд тогтсон хуваарийн дагуу шинжлүүлж байх	Төслийн талбай дахь худгийн усанд				ОХШХ-т тусгасан аар	+	MNS 3936:1986 Ундны ус-Тухайн талбартнь шинжилгээ хийх MNS 0900:2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
Стандартнийцсэн усаар хангах	Ундны усны стандарт хангасаар усаар ажилчдад үйлчлэх	Ундны усны хүрээнд					+	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлаг түүнд тавигдах шаардлага MNS 0900:2018
Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байх харьяанийтийн үйлчилгээний албатай хог хаягдлынгэрээ хийх	Ахуйн хатуу, шингэн хаягдлыг ил задгай хаяхгүй байх, ажилчидын бие засах газар болон бохир ус хуримтлуулах цэгийг холбогдох хууль, стандартын шаардлагад нийцүүлэн хүрээлэн буй орчныг бохирдуулахгүй байхаар төлөвлөх	Ахуйн хаягдлын хүрээнд				500.0	+	Усны тухай хууль, 2012 он Гүнийусыг бохирдолоос хамгаалах ерөнхий шаардлагууд. MNS 3342:1982
Нийт		1.500.0						

II.8 Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Жунзэнь” ХХК -аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

ОХШХ нь БОМТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Жунзэнь” ХХК батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-нд хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Жунзэнь” ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулна.



Зураг № II-1. Төслийн талбайн мониторингийн цэгүүд

Хүснэгт № II-7.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж 2023 он	Давт амжйн тоо	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Агаарын чанар								
1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	1.Төслийн үйл ажиллагааны үед агаарын чанарын дээжлэлт хийх 2.Төслийн үйл ажиллагааны үед ашиглах тээврийн хэрэгслийг жил бүр үзлэгт хамруулж, агаарын бохирдолын төлбөрийг төлөх, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх.	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 2 цэг сонгох зонхилох салхины доод ба дээд талд	Улирал тутамд	Жилд 2 удаа	40.0	Багажийн түрээсийн зардал: 1 багаж 40.0 х жилд 2 удаа* 1 жил НИЙТ 80.0	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
2	Агаарын тоосны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Уурхайн үйл ажиллагаанаас орчинд тоосжилт үүсэх, тархах	Хүдрийг буулгах овоолох цэгт	Улирал тутамд	Жилд 2 удаа	40.0	Шинжилгээний зардал: 1 удаагийнх 40.0 х 1 цэг х жилд 2 удаа *1 жил НИЙТ 80.0	

3	Дуу шуугиан, чичиргээ:	Машин механизмын ажиллагаа, хөдөлгөөнөөр шуугиан үүсэх	Хүнд даацын машины тээврийн зам, уурхайн ойр орчимд 2 цэгт	Улирал тутамд	Жилд 2 удаа	30.0	Багажийн түрээсийн зардал: 1 багаж 30.0 х жилд 2 удаа* 1 жил НИЙТ 60.0	
Хөрсний бохирдол								
1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Төслийн талбайд 2 цэг сонгох	Хагас жил тутамд	Жилд 1 удаа	30.0	2 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х 1жил /60.0/ НИЙТ 60.0 /Хөрсний химийн шинжилгээ 1 дээж- 60.0 төг,	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний

	Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох	Дээрх 2 цэгт	2025 он	Жилд 1 удаа	15.0	2 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х 2 жил х 30,0 Нийт 60 хүнд металлын шинжилгээ 1 дээж-30.0 төг/	болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Усны хяналт шинжилгээ								
1	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Төслийн талбай орчим	Унд ахуйн усыг хангаж буй уснаас	2025 он	Жилд 2 удаа	20.0	20.0*2 удаа х 1жил НИЙТ 40.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
2	Усны түвшин усны ундарга нөөц	Ус ашиглалтаас, зарцуулалтаас газар доорх усны горим өөрчлөгдөх	Төвийн шугамын ус	2025 он				
орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын 2025 оны зардлын дүн							380.0	

II.9 Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцан ажиллана.

“Жунзэнь” ХХК-ийн байгаль орчныг хамгаалах удирдлага зохион байгуулалт нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

1. Компанийн удирдлага
2. ХАБЭА-н инженер

Эдгээр 2 хэсгийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төлөвлөгөө, тайланг орон нутгийн удирдлага, байгаль орчны мэргэжилтнүүд, болон нутгийн иргэд, ТББ хянаж оролцож байхаар тусгав.

Хүснэгт № II-8. Удирдлага зохион байгуулалтын зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, сая.төг
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	Төслийн хугацаанд	Уурхайн дотоод төлөвлөлтөөр
2.	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаарх сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран жилд 1 удаа зохион байгуулах	Төслийн нийт хугацаанд	2.0
3.	Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Төслийн нийт хугацаанд	Осол эрсдэлийн МТ-нд тусгагдсан
4.	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр тогтмол хамруулах. Ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, хордлого тайлах хүнс, бэлдмэлээр хангаж байх	Төслийн нийт хугацаанд	Осол эрсдэлийн МТ-нд тусгагдсан
5.	Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах	Төслийн нийт хугацаанд	Осол эрсдэлийн МТ-нд тусгагдсан
6.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон аймгийн БОАЖГ-т хүргэн өгч байх	Жил бүрийн 12 сард	Уурхайн дотоод төлөвлөлтөөр
7.	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх сургалт, аян, уулзалт зөвлөлгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Төслийн хугацаанд	Уурхайн дотоод төлөвлөлтөөр

8.	Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 10 ¹ дүгээр зүйлд заасны дагуу Байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэх	Төслийн хугацаанд	8.0
9.	Тусгай зөвшөөрлийн талбайд газрын төлөв байдлын чанарын улсын хянан баталгааг хуулиар тогтоосон хугацаанд эрх бүхий байгууллагаар хийлгэж байх	Төслийн хугацаанд	6.0
Нийт зардал		16.0 төг	

II.10. БОМТ-ний хэрэгжилтийг оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгч "Жунзень" ХХК нь багийн иргэдийн нийтийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг жил тутамд хийнэ.

Хүснэгт № II-9. БОМТ-г оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Байгаль Орчин Уур, Амьсгал Өөрчлөлтийн Яам	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр дэлгэрэнгүй илэрхийлсэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна.	Жилийн эцэст (12.01-нд)	Цаашид төлөвлөгөөнд шинээр тусгах зүйлс	Улаанбаатар хот

Дорноговь аймгийн байгаль орчны газар	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр дэлгэрэнгүй илэрхийлсэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна.	Жилийн эцэст (11.01-нд)	Цаашид анхаарах зүйлс, Хамтран ажиллах	Улаанбаатар хот
Өргөн сумын Засаг даргын тамгийн газарт	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	Хагас жил, жилийн эцэст	Хамтран ажиллах	Өргөн сум
Өргөн сумын Иргэдийн Нийтийн Хуралд	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	Хагас жил, жилийн эцэст	Хамтран ажиллах	Өргөн сумын ИНХ

